



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

"Баянбүрд" чийрэгжүүлэлтийн төв байгуулах тухай

1. Улаанбаатар хотын Ардын Хурлын /хуучин нэрээр/ 16 дахь удаагийн сонгуулийн Ш чуулганаар баталсан "Эрүүл мэндийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Өрөн сууц нийтийн аж ахуйн компаний харьяа "Баянбүрд" үйлчилгээний төвийг Эрүүл мэндийн газрын мэдэлд эд хөгшил, тоног төхөөрөмжийн хамт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Нийслэлийн хүн амын эмчилгээ, чийрэгжүүлэлтийн түвшинг сайжруулах үндсэн үүрэгтэй "Баянбүрд" төв болгон зохион байгуулж, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын харьяанд ажиллуулсугай.

3. Дээрх барилгыг эд аж ахуй, тоног төхөөрөмжийн хамт энэ оны I улиралд багтаан хүлээн авч, "Баянбүрд" чийрэгжүүлэлтийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоон, дүрмийг баталж мөрдүүлэхийг нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар /н.Буян-Өлзий/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

[Handwritten signature]

Ц.БААСАНЖАВ